



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/810

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн үйл ажиллагаа явуулж буй МоЭнКо ХХК-ний Дарви суман дахь Хөшөөтийн нүүрсний уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн дарга: - Л.Батбаяр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Гишүүд:
- Ц.Сувдаа - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
 - Т.Бямбажаргал - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Г.Ганзориг - Мэргэжлийн хяналтын газрын хяналтын улсын байцаагч
 - Т.Оргилсайхан – Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргааны ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн
 - Н.Батболд - Дарви сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч
 - Ш.Дэмбэрэлдовдон - Дарви сумын байгаль хамгаалагч
 - С.Жамбалдорж – Дарви сумын Мөрөн багийн иргэн
- Нарийн бичгийн дарга: - Э.Амарбаясгалан - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн


Zax A/810 Ch

02 4053

2. Байгалийн нөөц баялаг ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, дүгнэлт гарган дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн даргад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Т.ЖАРГАЛСАЙХАН